



ТАВАН БОГД ФИНАНС ББСБ-ЫН

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ БОЛОН ЗАСАГЛАЛ /БОНЗ/-ЫН БОДЛОГО

V-1.0

2023 он

<p><i>Хамрах хүрээ:</i></p> <p><i>Таван Богд Финанс ББСБ ХХК</i></p>	<p><i>Хариуцах эзэн:</i></p> <p><i>Таван Богд Финанс ББСБ</i></p> <p><i>Бизнес хөгжил, маркетингийн алба</i></p>
<p><i>Хувийг хадгалах:</i></p> <p><i>Төлөөлөн удирдах зөвлөл,</i></p> <p><i>Хууль, эрх зүйн алба</i></p>	<p><i>Танилцах:</i></p> <p><i>Таван Богд Финанс ББСБ ХХК нийт</i></p> <p><i>ажилтнууд</i></p>
<p><i>Хүчинтэй хугацаа:</i></p> <p><i>2023 оны 07 сарын 01-ээс эхлэн</i></p>	<p><i>Хуудсын тоо:</i></p>
<p><i>Дараагийн үнэлгээ хийх огноо:</i></p> <p><i>2023 оны 07 сарын 01</i></p>	
<p><i>Холбогдох журам, тушаалын дугаар:</i></p>	<p><i>Хувилбар:</i></p> <p><i>V-1.0</i></p>

№	Хувилбар	Өөрчлөлт хийгдсэн огноо	Өөрчлөлтийн агуулга
1	1.0	2023 оны 09 сарын 04	Байгууллага бусад бодлого болон журам, дүрэмтэй уялдуулан анхлан боловсруулав.

АГУУЛГА

- 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ3**
- 2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ БОЛОН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО.....3**
- 3. БОНЗ-ЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГ ҮҮРЭГ 5**

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Байгаль орчин, нийгэм болон засаглалын /цаашид БОНЗ-ын Бодлого гэх/ бодлогын зорилго нь “Таван Богд Финанс ББСБ” ХХК-ийн бүхий л үе шатанд байгаль орчин, нийгэмд ээлтэй, зөв засаглалын үйл ажиллагааг нэвтрүүлэх, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн өсөлтийг хангах үүргийг биелүүлэхийн тулд баримтлах зарчмууд болон үүрэг хариуцлагыг тодорхойлоход оршино.
- 1.2. Энэхүү бодлого нь Таван Богд Группын “Тогтвортой Хөгжлийн Бодлого”-той уяалдан боловсруулагдсан болно.

2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ БОЛОН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 2.1. Таван Богд Финанс ББСБ ХХК нь НҮБ-ын тогтвортой хөгжлийн 17 зорилтууд (ТЗ), Тогтвортой Санхүүжилтийн Хөтөлбөрийн 8 зарчмыг удиртгал болгон бодлогын хэрэгжилтийн хугацаанд боломжит зорилтуудын хүрээнд байгууллагын хэмжээнд хүрэх үр дүнг тодорхойлж, үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллана.

Хүснэгт 1. НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн 17 зорилт

Зорилго	Зорилгын нэр	Зорилт	Үзүүлэлт
1	Ядуурлыг устгах	7	14
2	Өлсгөлөнг зогсоох	8	13
3	Эрүүл мэндийг дэмжих	13	27
4	Чанартай боловсролыг дэмжих	10	11
5	Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах	9	14
6	Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах	8	11
7	Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх	5	6
8	Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох	12	17
9	Инноваци болон дэд бүтцийн нэмэгдүүлэх	8	12
10	Тэгш бус байдлыг бууруулах	10	11
11	Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих	10	15
12	Хариуцлагатай хэрэглээг дэмжих	11	13
13	Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах	5	8
14	Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах	10	10
15	Хуурай газрын эко системийг хамгаалах	12	14
16	Энх тайван, шударга ёсыг цогцлоох	12	23
17	Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх	19	25
	Бүгд	169	244

Эх үүсвэр. <https://sdg.1212.mn/Home/Goals>

Тогтвортой хөгжлийн 17 зорилтууд болон Тогтвортой санхүүжилтийн 8 зарчмуудаас Таван Богд Финанс ББСБ-н БОНЗ-ын 4 үндсэн хэсэгт холбож өгсөн бөгөөд тусгагдаагүй бусад зорилт, зарчмууд нь хамаарахгүй гэсэн үг биш болно.

Зураг 1. Тогтвортой санхүүжилтийн 8 зарчим



Эх үүсвэр. Тогтвортой Санхүүжилтийн Холбоо

2.2. Таван Богд Финанс ББСБ ХХК-ийн БОНЗ-ын Бодлого нь үндсэн 4 бүрдэлтэй байна.



2.2.1. **Ногоон санхүүжилт (1)** – Бид дотоодын болон олон улсын санхүүжүүлэгч байгууллагуудын БОНЗ-ын хүрээнд хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдэд идэвхтэй хамрагдаж ногоон эх үүсвэр татаж байгальд болон нийгэмд ээлтэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг боловсруулж хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллана.

- Ногоон санхүүжилт – Байгууллага нь тогтвортой, ногоон хөгжлийг хангахад чиглэсэн санхүүжилт, эх үүсвэрийг татан төвлөрүүлэхэд чиглэнэ.
- Ногоон бүтээгдэхүүн – Байгууллага нь байгаль болон хүнд ээлтэй ногоон бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж ногоон санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж ажиллана. Түүнчлэн Монгол Улсын Тогтвортой Санхүүжилтийн 1 (Байгаль орчноо хамгаалах), 3 (Соёлын өвийг хамгаалах), 4 (“Ногоон Эдийн засаг”-ийн өсөлтийг дэмжих) тус тус зарчмуудыг баримтална.

- БОНЗ-ын эрсдэлийн удирдлага – Байгууллага нь БОНЗ-ын эрсдэлийн удирдлагын тогтолцоог үйл ажиллагааны бүхий л түвшинд хэрэгжүүлж ажиллана.

2.2.2. **Ногоон үйл ажиллагаа (2)** – Байгууллагын бүхий л үйл ажиллагаа нь тогтвортой хөгжил, байгаль орчин болон хүнд ээлтэй хандлага, зарчмыг эрхэмлэнэ.

Монгол Улсын Тогтвортой Санхүүжилтийн 2 (Хүний эрх, нийгмийг хамгаалах), 5 (Санхүүгийн хүртээмжийг дэмжих), 6 (Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих), 8 (Манлайлан үлгэрлэх) тус тус зарчмуудыг баримтална.

2.2.3. **Ногоон нийгэм (3)** – Бид нийгмийн хариуцлагатай байгууллага байж байгаль, нийгэмд чиглэсэн төсөл хөтөлбөр, үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, иргэдийн санхүүгийн боловсролыг дэмжин ажиллана.

Монгол Улсын Тогтвортой Санхүүжилтийн 2 (Хүний эрх, нийгмийг хамгаалах), 3 (Соёлын өвийг хамгаалах) гэх зарчмуудыг баримтална.

2.2.4. **Хамтын ажиллагаа болон тайлагнал (4)** – ББСБ нь дотоодын болон олон улсын зохицуулагч байгууллагуудтай урт хугацаанд хамтран ажиллах бөгөөд хамтын ажиллагаагаа эрхэмлэхээс гадна ил тод байдал, хариуцлагыг хангаж Тогтвортой санхүүжилт (ТоС)-ын үүрэг хариуцлагын хүрээнд тайлагнах явдлыг дэмжин ажиллана.

Монгол Улсын Тогтвортой Санхүүжилтийн 7 (Ил тод байдал, хариуцлагыг дэмжих) зарчмыг баримтална.

Түүнчлэн ББСБ нь “Ногоон хөгжлийн тайлан”-г олон нийтэд нээлттэйгээр жил бүрийн 3-р сард гаргах бөгөөд өмнөх оны гүйцэтгэл, үр дүн болон дараагийн жилийн зорилт, төлөвлөлтийг тусгасан байна.

3. БОНЗ-ЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГ ҮҮРЭГ

3.1. БОНЗ-ын бодлогыг ББСБ-ын дотоод болон гадаад үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлэх бөгөөд тухай бүр холбогдох бодлогуудаар зохицуулагдана.

Хүснэгт 2. Дотоод болон гадаад үйл ажиллагаа зохицуулах бодлогуудын жагсаалт

№	Бодлого, журам	ТоС 8 зарчим	ТЗ 17 зорилт
1	Хүний нөөцийн бодлого	Зарчим 2	Зорилт 3, 5, 8
2	Актив пассивын удирдлагын бодлого	Зарчим 6	Зорилт 8
3	Нябо бүртгэл бодлого, худалдан авалтын журам	Зарчим 4	Зорилт 7
4	Эрсдэлийн бодлого	Зарчим 6	
5	Комплайнсын бодлого	Зарчим 7	
6	Мэдээлэл технологийн бодлого, дата менежмент журам	Зарчим 5	Зорилт 9

7	Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, нууцын бодлого	Зарчим 5	
8	Аудитын дүрэм, шүгэл үлээх бодлого, ашиглангийн бодлого	Зарчим 7	Зорилт 10
1	Харилцагчийн бодлого, мерчантын бодлого	Зарчим 5	
2	Зээлийн бодлого	Зарчим 1, 3, 5	Зорилт 12, 13
3	Бүтээгдэхүүнийн бодлого	Зарчим 1, 2, 3, 4, 5	Зорилт 12, 13, 15
4	Маркетинг, борлуулалтын бодлого	Зарчим 3, 5	Зорилт 13
5	Хамтын ажиллагааны бодлого	Зарчим 6	Зорилт 17

--ooOoo--